

**“ЖИДАКС” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛ**

2024 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 1

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4-р сарын 22-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо, орхон-1, “Шинэ монгол хаад групп” ХХК-ийн байр, 2 давхарын хурлын танхимд хуралдав.

Хуралд оролцсон:

- | | |
|------------------|---|
| 1. Т.Төгс-Од | /Хурлын дарга/ |
| 2. Lee Jeoung Ho | /“Эм Ди Кэй Ай” ХХК-г/ төлөөлж – Хувьцаа эзэмшигч |
| 3. Б.Бумдэлгэр | /Тооллогын комиссын дарга/ |
| 4. Д.Гантуул | /ТУЗ-н Аудитын хорооны гишүүн/ |
| 5. Д.Булгамаа | /Нарийн бичгийн дарга/ |

Хурлын ирц:

Тооллогын комиссын дарга Б.Бумдэлгэрийн танилцуулснаар:

“Жидакс” ХК-ийн нийт гаргасан 13,735,752 ширхэг хувьцаа байгаагаас 13,735,752 ширхэг саналын эрхтэй хувьцаатай бөгөөд хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдөр буюу 2024 оны 4-р сарын 01-ний өдрийн байдлаар нийт 169 хувьцаа эзэмшигч байна. Үүнээс 13,560,394 ширхэг хувьцаатай “Эм Ди Кэй Ай” ХХК буюу 98,72 хувийн хувьцаа эзэмшигч хуралд оролцсоноор Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэхь заалт, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.4 дүгээр заасны дагуу хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцов. Оролцсон хувьцаа эзэмшигч:

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшил хувь
1	“Эм Ди Кэй Ай” ХХК-г төлөөлж Гүйцэтгэх захирал Lee Jeoung Ho	13,560,394	98.72%
Нийт		13,560,394	98.72%

Хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 03-р сарын 11-ний өдрийн 24/02 тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:

Хэлэлцэх асуудал 1: “Жидакс” ХК-ийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн танилцуулах,

Т.Төгс-Од: Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны болон санхүү байдлын тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах,

Lee Jeoung Ho: Компани төлөвлөгөө боловсруулан, ашигт орлогоо нэмэгдүүлэн ажиллах болно. Санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг батлах саналтай байна.

Шийдвэр 1:

Компанийн жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан болон санхүү байдлын тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 2: 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлт танилцуулах,

Хурлын дарга: Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны гишүүн Д.Гантуул жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийн тухай мэдээлэл өгнө.

Д.Гантуул: Санхүүгийн зохицуулах хорооны зөвшөөрөлтэй “Голден Пэйж” ХХК аудитын байгууллагыг сонгон, санхүүгийн тайланг хууль тогтоомжийн хүрээнд гаргуулж авсан. Асууж тодруулах зүйл байвал асууж болно.

Lee Jeoung Ho: Зөвшөөрөлтэй байгууллагаар аудитын үйлчилгээ хийлгэсэн байна, уншиж танилцсан. Нэмж хэлэх санал үгүй болно.

Шийдвэр 2:

2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын байгууллагын дүгнэлтийг БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 3: 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хувиарлах эсэх тухай ТУЗ-ийн тогтоол танилцуулах,

Т.Төгс-Од: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 2-р сарын 19-ний өдрийн 24/01 тоот тогтоолд 2023 оны санхүүгийн үр дүнтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хувиарлахгүй байх шийдвэрийг баталсан.

Lee Jeoung Ho: Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол шийдвэртэй санал нэг байна.

Шийдвэр 3:

2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хувиарлахгүй байхаар БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 4: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох,

Т.Төгс-Од: 2023 оны санхүүгийн тайлангаас харахад Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин урамшуулал олгох боломжгүй гэж үзэж байна.

Lee Jeoung Ho: Компани өргөжин тэлж ашиг орлого нэмэгдэх үед цалин, урамшуулал олгохыг зорин, дэмжин ажиллана.

Шийдвэр 4:

Компани 2023 онд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд цалин, урамшуулал олгохгүй байхаар БАТАЛСУГАЙ.

Хэлэлцэх асуудал 5: Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг танилцуулах,

Т.Төгс-Од: Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүнд дараах нэр бүхий гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан сонгох, нэг гишүүнийг чөлөөлж, шинээр нэг гишүүн томилох

Хараат бус гишүүд: - Лхагвасүрэн овогтой Ганчимэг
- Бямбаа овогтой Ариунболд
- Жаргалсайхан овогтой Билэгдэмбэрэл

Ердийн гишүүд: - Lee овогтой Jeoung Ho
- Төмөрбаатар овогтой Төгс-Од
- Бямбаа овогтой Нарантуяа
- Дашням овогтой Гантуул
- Дорлигжав овогтой Болормаа

Хурлын дарга: Одоо ажиллаж байгаа дээрх нэр бүхий гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан томилох, ердийн гишүүн Доржготов овогтой Пүрэвдоржийн бүрэн эрхийн хугацаа дуусан чөлөөлөгдөж, шинээр ердийн гишүүнд Гаравсэнгэ овогтой Хонгорзулыг томилох саналтай байна.

Lee Jeoung Ho: Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дээрх нэр бүхий гишүүдийг нэг жилийн хугацаатайгаар улируулан томилох, шинээр ердийн гишүүнд нэр дэвшигч Гаравсэнгэ овогтой Хонгорзулыг томилохыг тус тус зөвшөөрч байна.

Шийдвэр 5:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр дараах гишүүдийг улируулан, шинээр нэр дэвшигч Гаравсэнгэ овогтой Хонгорзулыг ердийн гишүүнээр тус тус СОНГОСУГАЙ.

Ердийн гишүүд:


- Lee овогтой Jeoung Ho
- Төмөрбаатар овогтой Төгс-Од
- Бямбаа овогтой Нарантуяа
- Дашням овогтой Гантуул
- Дорлигжав овогтой Болормаа
- Гаравсэнгэ овогтой Хонгорзул

Хараат бус гишүүд:

- Лхагвасүрэн овогтой Ганчимэг
- Бямбаа овогтой Ариунболд
- Жаргалсайхан овогтой Билэгдэмбэрэл нарыг сонгосугай.

Хурлын дарга Т.Төгс-Од хуралд оролцогсдод талархал илэрхийлж 15:00 цагт хурал өндөрлөв.

Тэмдэглэл хөтөлсөн:

 Д.БУЛГАМАА

Танилцсан Хурлын дарга:



Т.ТӨГС-ОД